

Д.Баярхүү

Сири дэх Оросын
байлдааны хоёр
жилд

Б.Индра

Си Зиньпин:
“Хятадын онцлогтой социализм
шинэ эрин үе рүү орлоо”

Toby Philpott

The Triumph of Emotion Over Logic:
The EU Referendum in the UK and
the Vote to Leave

БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2017 10 №5



Бодлогын судалгааны төв

Монгол Улсын Их Сургууль
Олон Улсын Харилцаа,
Нийтийн Удирдлагын Сургууль

РЕДАКЦИЙН ЗУРВАС

01

СУРГУУЛИЙН МЭДЭЭ

- 02** Num leadership conference Capacity development for transformation
“Нийтийн удирдлага дахь тогтвортой хөгжил”
сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал

ХӨРШ ОРНУУД

- 03** Сири дэх Оросын байлдааны хоёр жилд
- 06** Си Зиньпин: “Хятадын онцлогтой социализм шинэ эрин үе рүү орлоо”

ОЛОН УЛСАД

- 08** The Triumph of Emotion Over Logic: The EU Referendum in the UK and the Vote to Leave

Дугаарыг эрхлэн бэлтгэсэн:

Х.Бэхбат
Б.ИндраЭх бэлтгэгч:
Хэвлэсэн газар:Х.Балдандорж
“Удам Соёл” ХХК

Манай “Бодлогын мэдээ” нэлээд хэдэн сар завсарлаад дахин сэргэж байна. Завсарласны учир шалтгаан тодорхой. Харин энэ хооронд улс оронд маань болон олон улсын хэмжээнд чухал үйл явдлууд ар араасаа хөврөн нэгэнтээ ард хоцорчээ. Нэхэн санаж цаашдын хувьслыг нь угтан таамаглах үйл явдлын эгнээг “ардын” гэж овоглох гэсэн ч ард олон нь өөрөө тийм ч амархан адислахгүй “зовоож” байгаа шинэ засгийн газар тэргүүлж байх аж. “Давхар дээл”, “жаран тэрбумын” зэрэг асуудлууд ч амь бөх, удаан чиргүүлдэхийг тун саяхан Улаанбаатар хотноо болж өнгөрсөн олон улсын хоёрчиг хурлын явцаас харж болох байлаа. Нэг нь “Монгол Улсын Үндсэн хууль: 25 жилийн туршлага, сургамж”, нөгөө нь “ Нийтийн удирдлагын тогтвортой хөгжил” хэмээх сэдвээр болсон. Үнэхээр л тулгамдсан, чухал асуудлууд даа.

Хойд Солонгосын “цөмийн түгшүүр”, Сирийн дайн, Европын Холбооны хямрал гээд бэрх зангилаанууд үргэлжилсэн хэвээр. “Brexit”-ийн талаар нэгэн англи эрхмийн бичсэн өгүүллийг энд нийтлэхдээ хөрвүүлж түвдсэнгүй, хүлцэл өчсү. Харин ХКН-ын их хурал болж манай өмнөд хөршийн ойрын ирээдүйн бодлого нэн тогтвортой, хөгжлийн төлөв нь ихээхэн тодорхой болж буйг дэлхий даяараа олзуурхаж байна.

...Улс төр, улс төрчдийн талаар янз бүрийн хүмүүс, янз бүрийн юм ярьж хэлж, бичиж ирсэн байдаг. Гээх гэхээсээ авах нь арвин гэж бодогдохын учир тэр их далайгаас хааяа эшлэл “самардаж” байя гэснийг минь мэргэн уншигч Та болгооно буй заа.

Х.Бэхбат

* * *

“Politicians have the ability to foretell what is going to happen tomorrow, next week, next month, and next year. And to have the ability afterward to explain why it didn't happen.”

Winston Churchill

“He knows nothing; and he thinks he knows everything. That points clearly to a political career.”

George Bernard Shaw

NUM LEADERSHIP CONFERENCE: CAPACITY DEVELOPMENT FOR TRANSFORMATION

“НИЙТИЙН УДИРДЛАГА ДАХЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Энэ 2017 оны 10 дугаар сарын 18-нд МУИС-ийн ОУХНУС-ийн Нийтийн Удирдлагын тэнхим, манай улсын Төрийн Албаны Зөвлөл, Орон Нутгийн Тогтвортой Хөгжлийн Институт, ХБНГУ-ын Шпайрын Төрийн Захиргаа Судлалын Институт, мөн улсын Шпайрын Төрийн Захиргааны Их Сургууль, Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ), Тогтвортой Хөгжлийн Хүрээлэн, АНУ-ын Анкорержийн Аляскын Их Сургууль хамтран олон улсын эрдэм шинжилгээний ээлжит цуврал хурлаа “Нийтийн удирдлага дахь Тогтвортой хөгжил” сэдвээр амжилттай зохион байгууллаа.

Шангри-Ла зочид буудалд болж өнгөрсөн уг эрдэм шинжилгээний хуралд:

- ХБНГУ-ын Шпайрын Төрийн Захиргаа Судлалын Институтийн захирал, МУИС-ийн Хүндэт Доктор, Проф. Др. Цыков “Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх институцийн бүтэц”
- МУ-ын Төрийн Албаны Зөвлөлийн жинхэнэ гишүүн Др. С. Цэдэндамба “Монгол Улсын Төрийн Албаны өөрчлөлт шинэчлэлт: Тогтвортой хөгжлийн

хөтөлбөр 2030”

- Сингапур дахь Ази-Номхон Далайн Бүс, Японы SAP Их, дээд сургуулиудын холбооны захирал Криспиан Тан “НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн зорилтууд: Тоон программаар дамжуулан SAP-ийн оруулах хувь нэмэр”
- АНУ-ын Анкорез дахь Аляскын Их Сургуулийн Бизнес, Нийтийн Удирдлагын сургуулийн Проф. Др. Жон Даффи “Төрийн захиргаа ба тогтвортой байдал: Онол, практикийн нэгдэл”
- БНСУ-ын Нийтийн Удирдлагын Институтын Др. Өнжү Ким “Тогтвортой хөгжил: Орон нутгийн засаг захиргааны үүрэг”
- МУИС-ийн ОУХНУС-ийн Нийтийн Удирдлагын тэнхимийн эрхлэгч Проф. Др. Н. Бурмаа “Тогтвортой хөгжилд ойн менежментийн оруулах хувь нэмэр” сэдвээр тус тус илтгэл тавьсан нь хуралд оролцогчид, нийтийн удирдлагын мэргэжилтнүүд, төрийн албан хаагчдын анхаарлыг нийтийн удирдлагын тогтвортой байдалд хандуулсан чухал ач холбогдолтой болов.

Дээрх илтгэлүүдийг хэлэлцсэний дараа “Төрийн сектор тогтвортой хөгжиж чадах уу?”, “Төрийн

тогтвортой байдлын үзүүлэлтүүд: гүйцэтгэлийн цогц системийг бий болгох нь” сэдвээр тус тус салбар хуралдаан зохион байгууллаа.

Хуралд МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын эрдэмтэн багш нар, УИХ-ын Тамгын Газар, МУ-ын Төрийн Албаны Зөвлөл, Үндэсний хөгжлийн Газар, Буянт Ухаа дахь Гаалийн Газар, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хууль Сахиулах Их Сургууль, Батлан Хамгаалах Их Сургууль, Этүгэн Их Сургууль, Мандах Бүртгэл Дээд Сургууль, зарим Аймаг, Нийслэлийн ЗДТГ, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг, хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл уригдан оролцож сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлэв.

Тус хурал нь манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрчлөлтүүд гарч, төрийн захиргааны байгууллагууд шинээр зохион байгуулагдаж буй онцлог цаг үед тохиож, олон улсын судлаачид, мэргэжилтнүүдийн анхаарал, үзэл бодлыг нийтийн удирдлагын шинэчлэлд хандуулан, салбарын цаашдын судалгаа шинжилгээний ажлын төлвийг тодруулахад үнэтэй хувь нэмэр оруулж, практик ач холбогдолтой боллоо.



Д.Баярхүү

Олон улсын харилцааны судлаач-проф

СИРИ ДЭХ ОРОСЫН БАЙЛДААНЫ ХОЁР ЖИЛД

СССР-ийн өнгөн дээр хилийн чанадад явуулсан дайнуудых нь сүүлийг Афганистан дахь 8 жилийн ялалтгүй дайн мушгисан. Энэ гүрэн задран унахад эл дайн нэг нөхцөл, шалтгаан нь болж өгсөн. Түүнээс хойш Орос улс цэрэг-зэвсгээ хилийн чанад руу ийм олноор, удаан хугацаанд, амжилттай илгээсэн түүх өнөөгийн Сири дээр л давтагдлаа.

НЭГ.ҮР ДҮН БА ШАЛТГААН

Сирийн дайнд Орос яах гэж оролцов, Орост ямар ашигтай вэ гэх асуулт хоёр жил биднийг ээрлээ. Владимир Путины өөрийнх нь хэлснээр, “Хууль ёсны засаг-төрийг нь тогтвортой байлгах, улс төрийн харилцан буулт хийхийг нь нөхцөлдүүлэх” зорилготой 2015 оны 10 дугаар сараас тэр байлдаан эхэлсэн. Оросын ВКС буюу агаарын ба сансрын цэрэг нь анхны цохилтоо 2015.09.30-нд хийсэн ба үндсэн зорилгоо хангах анхны алхам нь “Лалын улс” (ISIL), “Жабхат ан-Нусра” (Аль-Каедагийн салбар, одоо “Хейат Тахрир аш-Шам” гэсэн нэртэй яваа) гэх террорист, жихадист бүлгүүдийг даран сөнөөх явдал байлаа.



Хоёр жилийн дүнгээр авч үзвэл Оросын ВКС нь 30 мянган агаарын дайралт хийж, 90 мянган цохилт өгчээ. Уг нь 90 мянган удаа бөмбөг тэсэлж, пуужин харвалаа гэхэд “Лалын улс” (ISIL), Жабхат ан-Нусрагийн тавь жаран мянган дайчин юутай хээтэйгээ сөнөчихмөөр. Гэтэл үр дүн нь туйлын чамлалттай. “Оросын цэргийнхэн Сирид 35 мянган боевикуудыг хөнөөлөө. Орчин үеийн 162 төрлийн зэвсгээ хэрэглэж туршлаа” хэмээн Батлан хамгаалахын сайд Сергей Шойгу жилийн өмнө сайрхан мэдэгдсэнээс үзвэл Орос нь Сириэс мөддөө гарахгүйгээр бэхжсэн мэт.

Башар Асадын дэглэмийн эсрэг сиричүүд босч тэмцээд 5 дахь жилээ үдэж байна. Үүнээс

гуравт нь тэрээр арай ядан дайралтыг зогсоож тогтоож байсан бол үлдэх хоёр жилд нь Оросын ВКС оролцсоноор ялалтаа бараг хангаж чаджээ. Нутаг дэвсгэрийнхээ 95 хувийг террорист жихадистуудаас чөлөөлөв. Нью-Йоркийн их сургуулийн профессор Марк Галеотгийн ажигласнаар Орос нь хоёр жилийг тун зөрчилтэй өнгөрөөжээ. Уг нь ISIL ба Жабхат ан-Нусра маягийн алан хядагчдын эсрэг цэргийн операцаа чиглүүлнэ гэсэн боловч Сирийн чөлөөт арми, сирийн ардчилсан хүчний эсрэг гэсгээлт явуулсан болж таарчээ. Асадын эсрэг л байвал бүгдийг нь цэргийн урлагийн өндөр түвшинд “машиндах”, тэгснээрээ Украинаас болж

олон улсын тавцанд унасан нэр хүндээ сэргээх, улмаар “Сирийн сэдэв”-ээр дэлхийн бусад гүрнүүдтэй (ялангуяа АНУ) наймаалцахыг зорьсон хэмээн проф. Галеотти бичсэн байх аж. Донбасст Орос бэхжиж авсан, Украин Дорнод бүс нутгаа хэзээ ч эргүүлж авч чадахгүй болсон, гэхдээ Оросын нэр хүнд бүр унасны дараа Путины гадаад бодлогын дараагийн үзэгдэл эхэлсэн, Украин дахь дайныхаа бүтэлгүйглээс дэлхий дахины анхаарлыг сарниулахаар Сирийг сонгосон хэмээн шведийн дипломат Андерс Осунд үзсэн нь анхаарал татахаар дүгнэлт юм.

ХОЁР. БАЙЛДААНЫ ЗОХИОМЖ

Ингэхэд Орос Сирид юу аваачихаад тулалдаж байгаа вэ? ВКС гэгчийн авиац, далай тэнгисээс харвах далавчит пуужингууд, цэргийн зөвлөхүүд, цэргийн цагдаа, спецназ буюу тусгай зориулалтын цэрэг, цэргийн хувийн компани гэгчид элссэн хөлсний цэргүүд. Ийм хүчээр Сирийн Засгийн газарт тусалж байна.

Байлдааны арга тактик нь гол төлөв агаараас Асадын цэрэг ба түүний холбоотнуудын (Иран, Ливаны цэргийн ангиуд, “Хэзболла” мэтийн отрядууд) цэргийн ажиллагааг дэмжинэ. Тэдний хяналтын бүсийг тэлэхийг хамтран зорино. 2016 оны сүүлчээр Алеппог эргүүлэн авсан нь тийм хоршсон хамтын ажиллагааны сонгодог жишээ. “Лалын улс”-ын хяналтын бүс, хил хумигдсаар дуусах тийшээ хандлаа. “Лалын улс” нефтийн

ордуудаа алдлаа. Зэвсэгт бүлгээ санхүүжүүлэх эх сурвалжаа алдлаа. Энэ бол Орос цэргийн хүчээр оролцсоны гавьяа гэдгийг ч нийтээрээ хүлээн зөвшөөрч байна.

Тиймдээ ч ОХУ-ын Гадаад хэргийн дэд сайд Сергей Рябковын нийтэд задалснаар, Орос, Америк хоёр цэргийн хэлхээ холбоо барьж, генералууд нь уулзалдаж байлдааны ажиллагаагаа зохицуулж буй. АНУ-ын хувьд Сирийн чөлөөт арми ба ардчилсан хүчин, курдын ба арабын босогчдыг зэвсэглэн, агаараас галаар дэмжих, босогчдын мэдэлд буй Сирийн умард нутагт Рожава гэх автономит засаг захиргааг хүлээн зөвшөөрүүлэх зорилготой. Америкчуудын гол тулж түших нь курдууд бол Орос нь Туркийг дэмжин Туркийн цэргээр тусгаар тогтнохыг хүссэн курдын анклавьг устгуулахыг зорино.

ГУРАВ. ХОХИРОЛ

Орос энэ дайнд оролцсоноор хүн хүч, санхүүгийн хувьд ихээхэн хохирол амслаа. Жилийн өмнө Алеппод Орос ихээхэн ач холбогдол өгч тулалдсан, ер нь Сири нь тэр чигтээ Оросын геополитикийн тоглолтын шинэхэн, алдаж болохгүй тавцан болсны хариу тусгал нь Анкарад Оросын Элчин сайдыг нь хөнөөсөн, Оросын Элчин сайдын араас дараагийнх нь гашуудал залгасан. Сири рүү чиглэн нисч явсан ОХУ-ын БХЯ-ны Ту-154 цэргийн онгоц 92 зорчигчтойгоо Хар тэнгист сүйрсэн. Хоёр жилд амь алдсан 40 цэргийн албан хаагчийг оролцуулаад

оросын 76 иргэн гэсэн тоо байна. Амь үрэгдэгсдийн дотор дэслэгч генерал Валерий Асапов, хурандаа Юрий Хабаров, хурандаа Степан Борщев гэхчлэн хүндэт нэрс жагсана. Орос хүний амь геополитикийн их тулааны дэргэд тун өчүүхэн ч юм шиг.

Санхүүгийн алдагдал нь өдөртөө л 2.3 саяас 4 сая ам.доллар хэмээх тооцоог британийн дүн шинжилгээний IHS Jane's сэтгүүл хоёр жилийн тэртээ хийж байсан. Дунджаар өдөртөө 2.5 сая долларын гарлагатай болов уу хэмээн таамагласан. АНУ ба түүний холбоотнууд өдөртөө 13.6 сая долларын гарлагатай (2014.08.08-наас 2017.06.30-ны хоорон дахь зарлагын албан ёсны илтгэл) гэж тооцоход оросынх өдөртөө 4 сая ам.доллар байх нь бараг ойролцоо болов уу. Өнөөг хүртэл АНУ ба холбоотнууд нь 14 тэрбум долларын зарлага гаргасан байна. 2016 оны гуравдугаар сард Путины хийсэн нэг мэдэгдэл байна. Сири дэх байлдааны операцад Орос төсвөөсөө 33 тэрбум рубль (570 сая доллар) өгсөн тухай, тэр үед Оросын төв банкны албан бус нэгэн тооцоогоор 2015 оны намраас тоолсон хагас жилд гэхэд л Сирид явуулсан байлдаандаа 38 тэрбум рубль (657 сая доллар) зарцуулсан бололтой юм. Хагас жилд хагас тэрбум доллар Сирийн дайны фронт руу Орос илгээсэн нь харагдаж байна. Оросын төв банкны өөр нэг тооцоо саяхан ил болжээ. Юу гэвэл Сири дэх операцдаа 58 тэрбум рубль (ойролцоогоор нэг тэрбум ам.доллар) зарцуулжээ. Энэ бол

зөвхөн цэргийн ажиллагааны зардал (байлдааны нислэг, пуужин харвалт, шатахуун, авиабаазын зардал гэх мэт). Цаана нь зөвхөн 2015 онд Сири нь Оросоос 19.7 сая долларын бараа таваар авсан дүн гарч байсан. Сири рүү юу, хэд хичнээн тоотой, ямар хэмжээтэй илгээсэн тухай гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримт Орост бараг байхгүй, 2016 онд тийм баримт бичиг үйлдээгүй, 2017 оны эхний хагаст Оросоос Сири рүү 16.1 сая долларын бараа бүтээгдэхүүн явсан бүртгэл байна. Буяны ба хандив тусламжийн зориулалтаар Сири нь өнгөрсөн хоёр жил хагасын дотор 36 сая ам.долларын (2 тэрбум рубль) бараа бүтээгдэхүүн авчээ гэсэн тооцоо интернэт мэдээнд байна.

Ингэхэд Сирийн дайнд Орос татагдан ороод ийм их санхүүгийн гарлага гаргасны сацуу олсон ашиг гэж бий юу гэх асуулт дагалддаг. Мэдээж маш олон цэргийн албан хаагч цалинжиж, ажил орлоготой байж, тэдний гэр бүл бэлжиж, цэрэг-арми бэхжиж, командлал нь туршлагажиж, хувийн цэргийн компаниуд (ЧВК) хөгжиж, мөн шинэ зэвсэг техникээ турших бэлээхэн полигон талбартай болж авлаа. Цэргийн аж үйлдвэрүүд захиалгад дарагдаж, тэр салбарын маш олон хүн ажил орлоготой болсон нь мэдээж давуу тал нь.

Шинэ шинэ зэвсэг техник (“Искандер”, “Калибр” гэх мэт тактикийн цөмийн зэвсэг зөөгч пуужин, Х-101 гэх нисэх онгоцны далавчит пуужин,

эргийн хамгаалалтын “Бастион” комплекс) бүтээсэн нь бүр ч том ололт гэж тооцогдоно. Радиоэлектрон байлдааны комплекс, “Тайфун-К” мэтийн хуягт машин, инженерийн роботехникийн машин, байлдааны роботууд, нисэгчгүй техник, холбооны хэрэгсэл гэхчлэн зэвсгээ өөрсдөө заримыг нь, ихэнхийг нь сирийн цэргийнхэнд эзэмшүүлэн сайтар туршуулжээ. Сирийн дайнд оросын зэвсэглэлд шинэхэн бүртгэгдсэн бөмбөгдөгч Су-34, сөнөөгч Су-35, Су-30, похилтын вертолет Ка-52, Ми-28, Ми-35 сайн байлдаж, түүнээс нь улбаалж оросын зэвсгийг дэлхий даяараа сонирхож худалдан авах хүсэлт захиалгаа тасралтгүй ирүүлж буй тухай Путин өнгөрсөн хавар мэдэгдсэн. Түүний ярьснаар бол 2016 онд оросын зэвсгийн экспорт 3 хувиар буюу 15 тэрбум доллар болсон ажээ.

Эдгээрийг том ололт хэмээн оросын цэргийнхэн, зохион бүтээгч эрдэмтэд нь үздэг бол Александр Кнобель, Бекхан Чокаев зэрэг гадаад худалдааны томхон мэргэжилтнүүд Оросын эдийн засагт хэтдээ цул гарлага, алдагдал хуримтлагдсан хэмээн үзэж байна. Оросын боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн төсвөөс хасан байж цэрэг-аж үйлдвэр рүү оруулж байгаа тул тэд зөв ч хэлсэн байх.

ДӨРӨВ. ИЗРАИЛЬТАЙ ХОРШЛОО

Жүүдийн төрт-улсын заналт дайсан Ирантай хоршин ажиллаж буй Орос Израильтай

яг тийм хэмжээнд холбогдож авчээ. Батлан хамгаалахын сайд Сергей Шойгу мөнөөхөн ТельАвивт айлчилж, өөрийн партнёр Авигодор Либермантай хэлэлцээ хийсэн ба ярилцсан сэдэв нь цэргийн, цэрэг-техникийн хамтын ажиллагаа, терроризмтой тэмцэх, бүс нутгийн нөхцөл байдал гээд ярайж байна. Ингэж айлчлахынх нь өмнө израилийн агаарын хүчин сирийн зенитийн батареийг сөнөөсөн, тэр нь оросын сирид өгсөн зэвсэг, оросын сургасан зенитчид болж таарсан. Шойгу эсэргүүцэл илэрхийлсэнгүй. Учир нь Орос, Израиль хоёр Сирийн агаарын орон зайд ажиллах «кодекс» гэгчээ тохирсон, гэнэт мөргөлдөхөөсөө зайлсхийх гэж тэгсэн. Дамаск ба сирийн боевикуудын хоорондын дайнд израиль нейтралитет сахиж байгаад Москва туйлын талархалтай хандаж буй. Орос, Израиль хоёр 2015 оны намраас, өөрөөр хэлбэл Орос Сирид байлдаж эхэлснээс байнгын хэлхээ холбоотой байгаа нь Оросын олон талт, зарим талаар олон нүүрт дипломат бодлогынх нь илэрхийлэл болов уу. Жанжин штабын орлогч дарга нар толгойлсон хамтарсан комисс байгуулсан ба Сирийн тэнгэрт аюулгүй байдлыг хангах хамтарсан сургуулилалт хийсэн мэдээ байна.

Энэ бүхнээс үзвэл Орос нь Сирид байрлаж байлдсан бус Ойрхи Дорнод, Араб ертөнцөд геополитикийн байр сууриа үлэмж бэхжүүлсэн гэж дүгнэж болох ажээ.

**Б.Индра**

ШУА-ийн Олон улсын харилцааны
хүрээлэнгийн судлаач, доктор (Ph.D)

СИ ЗИНЬПИН: “ХЯТАДЫН ОНЦЛОГТОЙ СОЦИАЛИЗМ ШИНЭ ЭРИН ҮЕ РҮҮ ОРЛОО”

Хятадын Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга Си Зиньпин 10 дугаар сарын 18-нд намын их хурлаа 3 цаг орчим тасралтгүй, балга ус ч бараг уулгүй итгэл уншиж нээсэн билээ. Их хуралд тавьсан илтгэлээс нь өнгөрсөн 5 жил хийгээд ирэх 5 жилийн хөгжлийн гол чиглэлийг харж болно. Бодлогын томоохон баримт бичгээс тухайн улсын бодлогыг хардаг бол Хятадад гол төлөв удирдагчдынх нь хурал дээр тавьсан илтгэл, хэлсэн үгээс бас бодлогын чиг баримжааг нь олж мэдэх боломжтой байдаг. Ингээд Си Зиньпиний илтгэлээс хятадын өнгөрсөн, ирээдүйн талаар цухасхан харцгаая.

ӨНГӨРСӨН ТАВАН ЖИЛД

ЭДИЙН ЗАСАГ:

“Хятад улс дэлхийн эдийн засгийн өсөлтийн 30 гаруй хувийг бүрдүүлж байна. Дэлхийд хоёр дахь том эдийн засаг хэвээр.” Олон жил 10-аас дээш хувиар өсөж байсан эдийн засаг нь нэг оронтой тоотой болж 6-7 хувиар өсөх болсноос үүдэн хийсэн “бүтцийн өөрчлөлт нь сайжирсаар байна”. “Бүсчилсэн хөгжлийн төслүүд эхлүүлж, амжилттай яваа” ажээ.

УЛС ТӨР:

Өнгөрсөн таван жилийн хугацаанд “тавын нэгдэл”-ийг урагшлуулж, “дөрвөн иж бүрэн” стратегийг хэрэгжүүлжээ. Ер нь Хятадын улс төрд иймэрхүү пароль шиг үг хэллэг их бий. “Тавын нэгдэл” гэдэг нь улс төр, эдийн засаг, соёл, нийгэм, экологи гэсэн таван салбарыг цогцоор нь хөгжүүлэх тухай юм. “Дөрвөн иж бүрэн” гэдэг нь Си Зиньпиний дэвшүүлсэн

үзэл санааг илэрхийлдэг бөгөөд Си-гийн онцлог, шинэлэг талыг илэрхийлсэн онол шахуу зүйл. Утга нь чинээлэг нийгэм, өөрчлөлт шинэчлэлт, хуулийн засаглал, намын шинэчлэлт гэсэн дөрвөн чиглэлийг иж бүрэн хөгжүүлэх тухай юм.

Өнгөрсөн хугацаанд мөн “13 дахь таван жилийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхэлсэн.” Бас “ардчилсан хуулийн засаглал сайжирсан” гэж үзжээ.

НИЙГЭМ:

“60 гаруй сая хүн ядуурлаас ангижирч, ядуурал 10,2-оос 4 хувь хүртэл буурчээ. Дундаж давхрага тэлсэн. Хөдөөд нийгмийн даатгалын тогтолцооны суурь бүрэлдсэн” гэх мэт үр дүнтэй.

Гадаад харилцаа:

“Хятадын онцлогтой их гүрний гадаад харилцааг хөгжүүлэв.” “Бүс, Зам” санаачилга хэрэгжүүлж эхэлсэн.

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Торгоны зам сан зэрэг санхүүгийн механизм бий болгов. АПЕК, Бүс, Зам, Их-20, БРИКС-ийн г.м дээд хэмжээний арга хэмжээг Хятадад зохион байгуулсан. Бүхэлдээ Хятадын гадаад бодлого их гүрний шинжийг агуулж идэвхжсэн.

НАМЫН ШИНЭЧЛЭЛТ:

“Нам ба улс орны дотоодод бугшсан идээ бээрийг арилгаж, намын амьдралд шинэ уур амьсгал бий болголоо” гэж дүгнэжээ. Энэ бол Си-гийн гол амжилтын нэг юм. Урьд хожид байгаагүйгээр авлигатай тэмцэж, 70 орчим мянган түшмэл авлигын хэргээр шийтгүүлсний дотор Намын төв хорооны Улс төрийн товчооны байнгын гишүүн асан хүнийг хүртэл шийтгэсэн нь социалист Хятадын түүхэнд анх удаа юм.

ИРЭХ ТАВАН ЖИЛ БА ИРЭЭДҮЙН ЗОРИЛТ

Си Зиньпин удирдлагад гарч ирээд “Хоёр 100 жил”-ийн зорилтыг дэвшүүлсэн: 2021 онд Коммунист нам байгуулагдсаны 100 жил гэхэд дундаж чинээлэг нийгэм байгуулах, 2049 онд БНХАУ байгуулагдсаны 100 жил гэхэд орчин үеийн социалист улсыг байгуулах юм. Эхний 100 жилийн зорилт буюу 2021 онд дундаж чинээлэг нийгэм байгуулах зорилтыг барианд оруулах нь 19-р их хурлын 5 жил зориулагдах чухал түүхэн үүрэг даалгавартай хугацаа юм.

Хурлын илтгэлд ирэх 5 жилээс гадна 2020-2050 он хүртэлх 30 жилийг авч үзсэн ба тэрхүү 30 жилийн эхний хагаст бүх салбарт хуулийн засаглал, тогтолцоог төгсжүүлэхэд анхаарах бол сүүлийн хагаст нь иргэншлийг төгөлдөршүүлж орчин үеийн социалист улс болох зорилтдоо хүрэх ажгуу.

ЭДИЙН ЗАСАГ:

Хурдтай өсөлтөөс чанартай өсөлт рүү шилжих, хэрэглээг дэмжсэн бүтцийн өөрчлөлтөө үргэлжлүүлэхийн зэрэгцээ “нийлүүлэлтийн талын чанарыг сайжруулахад анхаарна” гэжээ. Эдийн засгийг хөгжүүлэх талаар инноваци, хөдөөгийн хөгжил, социалист зах зээлийн тогтолцоо гэх мэт зургаан зүйлийг дурдсан нь үндсэндээ өнгөрсөн таван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн чиглэлүүд байлаа. 18-р их хурлын илтгэлээс ялгаатай тал нь бүсчилсэн хөгжлийн уялдааг энэ удаагийн илтгэлд зүйлчлэн онцложээ.

УЛС ТӨР:

Намаар удирдуулах, ард түмэн эзэн мэдэх, хуулийн засаглал гурвыг уялдуулах тухай зүйлчлэн ярьсан нь өмнөх их хурлын илтгэлээс ялгарах тал нь байв. Коммунист нам улсаа удирдана, ингэхдээ гагцхүү хуулийн дагуу л засаглах ёстой

гэсэн санааг бататгасан хэрэг. Энэ бол авторитар дэглэмтэй улсад маш чухал зүйл билээ. Гэхдээ зөвшилцлийн ардчилал, парламентаар дамжуулж ард түмэн засаглах эрхээ эдлэх, засаг захиргааны шинэчлэлт гэх мэт агуулгыг хөндсөн нь шинэ зүйл биш бөгөөд эд бүгд нь Хятадад социалист ардчиллын тогтолцоог боловсронгуй болгож буй явц гэж үздэг.

НИЙГЭМ:

Боловсролыг хүртээмжтэй байлгах, ажлын байр бий болгох, ядуурлаас ангижрах, нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулах гэх мэт байнга дурддаг нийгмийн асуудлуудаас гадна үндэсний аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг зүйлчлэн онцолсон нь сонирхол татаж байлаа. Дээр дурдсан нийгмийн зөрчилтэй бас холбоотой ч биз, ямартаа ч ирэх таван жилд нийгмийн аюулгүй байдал, түүнийг хангах тогтолцоог боловсронгуй болгох талаар түлхүү ажиллах нь гэж харж болно.

ГАДААД ХАРИЛЦАА:

Улс орнуудтай түншлэх, түншийн харилцааг хөгжүүлэх чиглэл хэвээр байна. “Бүс, Зам”-ыг урагшлуулж, бодлогын уялдаа, дэд бүтэц, худалдаа, санхүү, иргэд хоорондын гэсэн таван чиглэлээр хамтарч ажиллахаа үргэлжлүүлнэ. Олон улсад хамтын хөгжлийг эрэлхийлнэ.

Харин 18-р их хурлын илтгэлд байсан “шинэ төрлийн их гүрний харилцааг хөгжүүлэх” томъёоллыг Си Зиньпин илтгэлдээ дурдсангүй. Харин “Их гүрнүүдтэй зохицуулалт, хамтын ажиллагаагаа сайжруулж, бүхэлдээ тогтвортой, тэнцвэртэй их гүрнүүдийн харилцааг бий болгоно” гэжээ.

Хөрш орнуудтайгаа “ойр

дотно, чин сэтгэлээсээ, ашигтай, хүртээмжтэй” харилцах тухай бодлогыг 2013 онд Си Зиньпин томъёолж хэрэгжүүлсэн нь сая ийнхүү намын их хурлын илтгэлд бичигдлээ. Түүнчлэн хөгжиж буй орнуудтай, улс төрийн намуудтай харилцаагаа хөгжүүлэхээр дурдсан байна.


НАМЫН ШИНЭЧЛЭЛТ:

Улсыг нам удирддаг, тэгвэл намыг хэн, хэрхэн хянах билээ. Си-гийн илтгэлд нам өөрийгөө хянана, бас ард түмнээр хянуулна гэжээ. Нам өөрийгөө хянана гэдэг нь эрх мэдлийг тогтолцооны торонд хаших замаар хэрэгжинэ, ард түмэн хянана гэдэг нь улс, муж, хот, гацаа хүртэл бүх түвшинд хяналтын зөвлөл байгуулж, эхлээд туршилтын журмаар ажиллуулах ажээ.

Намын их хурлын илтгэлд гадаадын хэвлэлүүдийн хийсэн ажиглалтаар Си-гийн илтгэлийн түлхүүр үгс нь “хүчирхэг улс”, “зөрчил”, “шинэчлэлт” байжээ. Мөн эдийн засгаас илүүтэй улс төрийн өнгө аяс жин дарсан илтгэл болсон гэжээ.

Юутай ч 2020-21 онд дундаж чинээлэг нийгэм байгуулах олон жилийн зорилтоо барианд оруулахын төлөө хятадууд юу юунаас илүүтэйгээр цөм нэгэн зүгт хандах шаардлагатай чухал цаг үедээ тулсан бөгөөд тэрхүү нийгэм рүүгээ Си Зиньпин хэмээх лидерээр удирдуулан алхан орохоор бэлтгэж буй ажээ. Гэвч “зөрчил” хэмээх мөн ч олон сорилтыг давах хэрэгтэй болно.

2021 онд дундаж чинээлэг нийгэм байгуулаад 2050 он гэхэд Хятад улс орчин үеийн социалист улс болоод зогсчихгүй. Тэд “Коммунизмд хүрэх нь намын эцсийн зорилго, түүхэн үүрэг нь” болой.



Toby Philpott

*An International development consultant working in Mongolia,
Senior Private Sector Development Expert on EU TRAM Project*

THE TRIUMPH OF EMOTION OVER LOGIC: THE EU REFERENDUM IN THE UK AND THE VOTE TO LEAVE

Britain's narrow vote to leave the European Union in June 2016 exposed in all its horror a country that was seriously divided against itself. It also sent shockwaves around the world. In the first of a series of articles about Brexit and Britain's tortured relationship with the European Union, Toby Philpott, an international development consultant working in Mongolia, talks about some of the troubled history of Britain and the European Union leading up to the historic vote on 23rd June 2016 and what went wrong for those who favoured remaining in the EU.

David Cameron announced on the 20th February 2016 that there would be a referendum on Britain's continued membership of the European Union. Cameron had spent several months seeking a better deal for the United Kingdom within the European Union with the other 27 Member States. He had sold his position on a claim that if the other 27 members were flexible then he would be able to win a Referendum on the deal. Cameron staked his position on ensuring that Britain would remain. It would prove to be Act 1 in a tragedy of errors by Conservative politicians (Act 2 would be Mrs May's attempt at a power grab in the General Election of June 2017 which spectacularly backfired). It would also lead to the creation of a huge

rift in British society which may never fully heal.

I returned to vote in my home town of Folkestone which is a seaside town on the south-eastern coast of England facing France that has been in decline since the 1970s like several coastal towns in England. The town is just 12 kilometres south-west of the famous White Cliffs of Dover. Despite the local Member of Parliament for Folkestone and Hythe being pro-Remain, the sentiment within the town was decidedly ugly towards Brussels and towards foreigners. This had manifested itself with the UK Independence Party gaining several county and local council seats. There appears to also have been some resentment towards immigrants from Eastern

Europe who had arrived in the town since 2004. The mood was getting ugly over time and the Conservative Party was slowly losing Eurosceptic voters in towns up and down the country like Folkestone to Nigel Farage and UKIP.

From the firing of the starting gun in February 2016, all the logic was on the side of the Remain campaign. The economic, political and cultural arguments were strongly in favour of Britain remaining a member of the European Union. The country had also, as part of the European Union continued to be a strong presence on the international stage and was the member of arguably the most successful trading bloc since the rapid expansion of the Mongol Empire under Chinggis



Khan and subsequent Khans and the fledgling Hanseatic League in the 13th Century.

There had also been a successful Remain campaign in 1975 when the then Prime Minister Harold Wilson had gone to the country for a Referendum to ask it if it wished to remain part of the European Economic Community which it had joined just two years before in 1973. Then the result had been a resounding yes to stay in what was then called “The Common Market”. In British politics referendums are often called as the result of divisions within the political parties in the UK that party leaders are unable or unwilling to address directly. It is a mechanism Prime Ministers can use to avoid having to take hard decisions. It also undermines the idea of Parliamentary Sovereignty, although, technically referenda are not legally binding under British Administrative and Constitutional Law (the UK does not have a written constitution, unlike Mongolia). Referenda are technically “advisory” under British Law and it is ultimately

up to Parliament to decide whether to take any notice of the result or not.

The 2016 vote was more about resolving divisions in the Conservative Party rather than the country. In 1975 it had been about resolving divisions within the Labour Party rather than the country.

Unfortunately, those of us who were pro-Remain were to ignore the emotional factors that would be unleashed by the various Leave campaign groups to undermine the rational, logical position. It was our logic which was, in fact our biggest weakness since it made us look remote, out of touch with the concerns of ordinary people and easy to attack through the creation of a classically divisive “us and them” strategy. The “liberal, metropolitan elite” or “the experts” were the “them” versus the ordinary worker/person the “us”.

The Remain campaign was hamstrung by a belief that rational debate would triumph emotion since the arguments to remain, were and still are on

paper, very compelling. Britain has benefitted significantly from European Union membership and the benefits of access to the Single European Market. There are additional benefits from pooling sovereignty and allowing (relatively) free movement of goods, workers and capital. These had ensured that Britain has been able to access skilled labour from abroad, has enjoyed pre-eminence in financial services both within the EU and internationally and has successfully attracted significant inward investment. Thanks to the UK’s membership of the EU, significant inward investment was attracted from Japan in the 1980s and 1990s. The Japanese were also attracted by Britain’s skilled and semi-skilled workforce and several major automotive plants were built and made a significant contribution to employment in several economically depressed areas such as Sunderland in the North East of England, the former coalmining valleys of Wales etc. which had been hit by serious levels of unemployment because of major structural adjustments.

Those regions had also benefitted heavily from European Union Structural Funds since the 1970s. These funds have helped, and continue to help, disadvantaged regions within the European Union (defined as having a to improve their economic position through the funding of infrastructure and various interventions to support economic regeneration. Replacing these funds will be a serious challenge for the UK Government post-Brexit.


Ironically though, despite the major contribution of inward investors and EU Structural Funds it was in precisely those areas when the vote came in that voted to leave the EU. What caused such an illogical, irrational result? My personal view is that several factors were at play here:

United Kingdom Governments have had a convenient scapegoat in the European Union and has always been ready to pile blame on “remote and out of touch unelected faceless bureaucrats (or unelected commissioners) in Brussels” and other such inflammatory rhetoric for problems in the UK. They have been aided and abetted in this by an odious right-wing anti-foreigner press in the UK which is concentrated in the hands of a small number of press barons. The press barons use their newspapers to seek to use “public opinion” to attempt to intimidate and shame politicians (and more lately academics and judges) into supporting their anti-EU and anti-immigrant views. Rupert Murdoch, one notorious press baron is alleged to have stated “When I go into Downing Street they do what I say; when I go to Brussels they take no notice.”

There is also an historic legacy too. Originally, when the Treaty of Rome was being negotiated between the six

founding states (France, West Germany, Luxembourg, the Netherlands, Belgium and Italy) the United Kingdom observed but did not finally participate in the formation of the then European Economic Community. This was despite former Prime Minister Sir Winston Churchill being one of the strongest advocates for the integration of Europe to ensure that war on the European Continent would finally be unthinkable. Instead, the United Kingdom worked collaborated with five other countries to create the rival European Free Trade Association (EFTA) in 1960 which, like the EEC, is a customs union. The UK did eventually realise it had made a mistake, that the EEC was going to be successful and so sought membership. Unfortunately, there was a major block to our accession in the shape of President Charles De Gaulle who had developed such a deep and abiding affection for the UK whilst being hosted by us as leader of the Free French during World War two that he vetoed our applications to join twice (in 1963 and 1967). His veto was on the grounds of our perceived excessive closeness to the United States. Undeterred, the UK continued to seek membership (eased by the departure of De Gaulle in 1969). Eventually, after much diplomacy, the UK application was

This did not stop the UK hankering for membership though. After much tortured discussion and problems with vetoes from General Charles De Gaulle (who evidently had developed such a deep and abiding affection for Britain whilst hosted there as leader of the Free French during World War 2 that he blocked us joining the EEC twice – in 1963 and 1967) French resistance eventually gave way after the



watershed of the resignation of De Gaulle from the French Presidency in 1969.

This paved the way for the United Kingdom to finally join the then European Economic Community on 1st January 1973 (with Ireland and Denmark also joining). The ambivalence towards the UK and the UK towards the EU due to the De Gaulle vetoes had left a mark and matters were not improved when Margaret Thatcher (who was a strong supporter of continued EEC membership in 1975) began a sometimes-acrimonious relationship with the European Commission and some of the other



EU Member States over the UK's contribution to the EU Budget starting from the early 1980s. She was known as the "Iron Lady" not just for domestic political reasons but also for her perceived tough way of negotiating with our European partners. Her toughness in dealing with "Brussels" became a kind of benchmark against which other Prime Ministers were subsequently judged. Ironically, it was her perceived overstepping of the mark with our European partners which led to her being forced to resign her premiership in 1990 after resignations by both Nigel Lawson, the then Chancellor of the Exchequer (equivalent

to the Minister of Finance in Mongolia) and Geoffrey Howe, the Foreign Secretary (equivalent to the Minister of Foreign Affairs in Mongolia)

Another factor has been perceptions of the "European project" itself by voters in the United Kingdom. Many older voters (mostly those over 65) felt that they were merely joining an economic common market (my own Mother is amongst such voters) They did not appreciate that the logic of a single market could be that it is not just goods that flow, it is people and capital too. After further accessions where the EU grew from 6 in 1957 to 9 in

1973 to 10 in 1981, 12 in 1986, 15 in 1995 (Norway narrowly voted not to join despite acceptance), 25 in 2004 (including several Eastern European former Soviet Satellite States), 27 in 2007 and 28 in 2013 which allowed (on the main) free movement of people this gave some in the UK the perception that British people were losing their jobs to foreigners. The fact that these hard working, highly skilled Eastern Europeans were often doing jobs that British people did not wish to do themselves did not seem to register This unease was exploited by political parties such as the UK Independence Party to suggest that somehow the UK

had lost control of its borders (a fabrication - but a powerful one which the Leave campaign was able to exploit).

The biggest nail in the coffin of our continued membership though was the exploitation of an institution that has a deep importance in the psyche of the British. Although, ironically, the majority of those who led the campaign for the UK to leave the EU are ideologically opposed to socialised medicine and are strong critics of the perceived wastefulness and unaffordability of this institution, they wanted to use another emotional argument against the EU. A ludicrous claim (which has ludicrously recently been reasserted by Boris Johnson, the Foreign Secretary) was made that J350 million was being sent by the UK Government to Brussels each week as our contribution to the EU budget.

This is false (the UK Statistics Authority even publicly criticised the Leave Campaign for dishonesty) and the real level is a fraction of that once rebates and receipts of structural funds and other EU transfers back to the UK are made (some estimates are that the real figure is around 40% or around J140 million. The Vote Leave campaign splashed this false figure on the side of red buses which they drove around the country with another emotive appeal "let's fund our NHS (National Health Service) instead".

It was the worst kind of dishonesty, but it was highly effective once linked to an emotive appeal to nationalistic voters who dislike the idea of sending money abroad. These voters also believe that more money should be spent on public services (generally speaking, mostly Labour Party voters in skilled and semi-skilled

jobs). It was the famous American poet Maya Angelou who said: "I've learned that people will forget what you said, people will forget what you did, but people will never forget how you made them feel." The Vote Leave campaign was very effective at making people feel that the EU was a bad idea and that somehow Britain would be better off alone.

The detailed breakdown of results has showed a nation which is deeply divided on age group, socio-economic status, location, educational attainment and even within the Government itself. Young people aged 18-24 voted by three to one to remain in the European Union (although apparently only 36% actually voted according to). Amongst the 24-49 age group it was closer with 56% voting to remain and 44% voting to leave. Above the age of 50, the majority of voters voted to leave (56% to leave for those aged 50-64 and this figure rose to 61% amongst those aged over 65). Therefore, the older population (who, incidentally were far less likely to have a university education and also had been less likely to have lived and worked abroad) had imposed Brexit on the younger population. Evidence from exit poll data suggested that the higher the level of educational attainment, the more likely they were to vote Remain. Another factor was the level of median income. If median income in an area was above J30,000 then that area was more likely to vote Remain than areas with lower median income.

The vote to leave the EU has exposed deep social divides within the United Kingdom. It has also resulted in a higher level of antagonism towards immigrants with hate crimes rising by close to 100% in the months following

the Brexit vote. Furthermore, the referendum resulted in the first political assassination of a Member of Parliament in Britain since 1990 when Labour Member of Parliament, Jo Cox who was a strong advocate to remain in the EU was murdered by a far-right pro-Leave extremist in her constituency of Batley and Spen in West Yorkshire.

The United Kingdom had, for a while, a good reputation for being a liberal, tolerant society. This is now unravelling as Brexit supporters have felt emboldened to attack those who disagree with them. The Daily Mail newspaper has, since Brexit, felt so emboldened as to launch attacks on the judiciary - branding judges "Enemies of the People" who agreed that Parliament should have a vote on the triggering of Article 50 and is currently attacking academics who are opposed to Brexit in Universities by encouraging students to "inform" on them).

The horrible reality today is this. The United Kingdom is disunited, the Government is pitifully disorganised on the Brexit negotiations with the EU (the subject of my next article) and pro-Europeans like myself are in despair and under attack from a right-wing press which resorts to tactics more appropriate to Nazi Germany in the 1930s to seek to ostracise and silence us in wider British society for daring to say that the Brexit process is a disaster that should be stopped since it is not in the national interest.

Toby Philpott writes this article solely in a person capacity and all views expressed are his own. His views should, in no way, be construed as the views of any organisation or project in Mongolia.


МОНГОЛ УЛСЫН ЯДУУРЛЫН ЧИГ ХАНДЛАГАД НӨЛӨӨЛСӨН ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛС (2010-2016)

Эх сурвалж: 2010, 2012, 2014, 2016 оны ӨНЭЗС-г ашигласан ДБ-ны ажлтын гаргасан тооцоолол

- Албан ёсны тооцооны үр дүнгээс харахад, Монгол Улсын ядуурал 2014 ба 2016 оны хооронд (21.6% байснаа 29.6% болж) 8 пунктээр өсчээ;
- Энэ өсөлт нь тус улсад 2010 оноос хойш ядуурлын түвшин буурах хандлагатай байсныг зогсоолоо. Гэвч 2016 оны ядуурлын түвшин 2010 оныхоос доогуур хэвээр байна.



- Хот суурин газартай харьцуулбал хөдөө орон нутагт ядуурал илүү хэвээр байна (хөдөөд 34.9%, хотод 27.1%) ...
- ..гэвч хот, хөдөөгийн ядуурлын түвшингийн ялгаа (15.9 пункт байснаа 7.8 пункт болж) буурчээ.



- ...сүүлийн үед ядуурал 8 пунктээр өссөний дийлэнх хэсэг нь (нийт өсөлтийн 5 пункт) хот суурин газарт, багахан хэсэг нь (үлдсэн 3 пункт) хөдөө орон нутагт нэмэгджээ.
- (2010-2016) оны хоорондох хугацааг бүхэлд нь авч үзвэл үзүүлэлт эсрэгээрээ буюу ядуурал хөдөө орон нутагт илүү буурчээ.




- Хот суурин газрын хүн амын дийлэнх хэсгийг хот суурин газар (нийт ядуучуудын 62.1 хувь), ялангуяа Улаанбаатар хотод (37.8 хувь) одоо амьдарч буй ядуучууд эзэлж байгаа бөгөөд ...



Үндэсний статистикийн хороо

НОМЫН ЕРТӨНЦӨӨР



ОРОС, ХЯТАДЫН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭРҮҮД (1689-1947)

Арван зургаан жилийн тэртээ хэвлүүлж байсан “Орос-Хятадын гэрээ хэлэлцээрүүд” номоо дахин хэвлүүллээ. Хоёр хөршийн хооронд 1689-1949 оны хооронд байгуулсан, Монгол Улсын хувь заяанд нөлөөлсөн олон чухал баримт бичиг энэ номд бий. Манайд тэр бүр олддоггүй байсан эдгээр түүхэн баримтын ихэнхийг Стратегийн судалгааны хүрээлэнд ажиллаж байх үедээ Тайваний түүхийн архив, номын сангуудаас олж цуглуулж, эртний хятад хэлнээс монгол хэлнээ чадан ядан хөрвүүлэн буулгаж байж билээ. Нэрт түүхч, хятад судлаач Чулууны Далай агсан номыг маань хянан тохиолдуулахад оролцож, түүхэн тайлбаруудыг хийхэд туслалцаа үзүүлж байсан нь эргээд бодоход нэн олзуурхууштай, гүн бишрэлтэй. Гурван жил гаруй “ноцолдож” орчуулсан 57 баримт бичиг энэ номд буй. Түүх сонирхогчид, судлаач эрдэмтэд, үнэ цэнэтэй түүхэн баримтаар номын сангаа баяжуулагч олон хүн номыг маань сонирхож, цөөн тоогоор хэвлүүлсэн анхны хэвлэл нь удаж төдөлгүй олдохоо больсон билээ. Цагийн уртад хүмүүс асууж сураглах болсон тул номоо дахин хэвлүүллээ. Таны мэдлэгийн санд дусал ч атугай нэмэрлэх болтугай. Дараагийн номоо таны гар дээр тавихын төлөө хичээн ажиллаж байна. Номын цагаан буян арвижиж, улс Монголд минь амар амгалангийн үр үргэлжид дэлгэрэх болтугай.

📍 Монгол улс, Улаанбаатар хот, СБД,
МУИС-ОУХНУС V байр 308 тоот

✉ thinktanks99@gmail.com

☎ 976 99070579

📠 976-11354610